



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2016 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "Д", 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын "Зөв Монгол хүүхэд" хөтөлбөр батлах тухай 2013 оны 295 дугаар тогтоол, Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн "Боловсрол-2016" дэд хөтөлбөр батлах тухай 2013 оны 112 дугаар тогтоол, "Нийгмийн баталгааг хангах" дэд хөтөлбөр батлах тухай 2014 оны 83 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд нэг бүрийн хөгжил, төлөвшилд гарч буй ахиц, амжилтыг дэмжих, авьяас чадварыг нээн хөгжүүлж буй багш нарын хөдөлмөрийг бодитой үнэлж урамшуулах зорилгоор сургуулийн өмнөх, бага, дунд боловсролын багш нарын "Сайн хичээл, хөгжүүлэх үйл ажиллагаа"-ны чанар, хүртээмж, үр дүнг хүүхэд нэг бүрийн сурлага, хөгжил, төлөвшлийн ахицаар үнэлж, урамшуулал олгох журмыг хавсралтаар баталсугай.

2. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг дүүргийн засаг дарга Д.Ганболдод үүрэг болгосугай.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ



**СУРГУУЛИЙН ӨМНӨХ, БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН БАГШ НАРЫН
“САЙН ХИЧЭЭЛ, ХҮҮХЭД ХӨГЖҮҮЛЭХ САЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА”-НЫ ЧАНАР,
ХҮРТЭЭМЖ, ҮР ДҮНГ ХҮҮХЭД НЭГ БҮРИЙН СУРЛАГА-ХӨГЖИЛ-ТӨЛӨВШЛИЙН
АХИЦ, АМЖИЛТААР ҮНЭЛЖ, УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Чингэлтэй дүүргийн төрийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш нарын сайн хичээл, хүүхэд хөгжүүлэх сайн үйл ажиллагааны чанар, хүртээмж, үр дүнг хүүхэд нэг бүрийн сурлага, хөгжил, төлөвшлийн ахиц амжилтаар үнэлж, урамшуулал олгоход журмыг мөрдлөг болгоно.

1.2. Монгол Улсын Засгийн газрын “Зөв Монгол хүүхэд” хөтөлбөр батлах тухай 2013 оны 295 дугаар тогтоол, Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн “Боловсрол-2016” дэд хөтөлбөр батлах тухай 2013 оны 112 дугаар тогтоол, “Нийгмийн баталгааг хангах” дэд хөтөлбөр батлах тухай 2014 оны 83 дугаар тогтоол нь журмын эрх зүйн үндэс болно.

1.3. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд нэг бүрийн хөгжил, төлөвшилд гарч буй ахиц, амжилтыг дэмжих, авьяас чадварыг нээн хөгжүүлж буй багш нарын хөдөлмөрийг бодитой үнэлж, урамшуулах, нийгмийн баталгааг хангахад энэхүү журмын зорилго оршино.

1.4. Журамд нэмэлт өөрчлөлт оруулах, хүчингүй болгох асуудлыг дүүргийн Засаг даргын санал болгосноор Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид шийдвэрлэнэ.

Хоёр. Баримтлах зарчим

2.1. Ил тод, нээлттэй байна.

2.2. Багшийн өөрийн үнэлгээнд тулгуурласан байна.

2.3. Үнэлэх аргачлал нь хэмжигдэхүйц, бодитой байна.

2.4. Хамт олны оролцоог хангасан байна.

Гурав. Ажлын зохион байгуулалт, үе шат

3.1. Сургуулийн өмнөх боловсролын багшийг хүүхэд нэг бүрийн давуу тал, онцлогт тулгуурласан хөгжүүлэх үйл ажиллагаа, хүүхэд нэг бүрт үзүүлж буй дэмжлэг, багш-эцэг эхийн хамтын ажиллагаа, хүүхэд нэг бүрт гарсан хөгжил, төлөвшлийн ахиц, амжилтаар, ерөнхий боловсролын багшийг хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх сайн хичээл, төлөвлөлт, эцэг эх, олон нийтийн оролцоотой сайн үйл ажиллагаа, хүүхэд нэг бүрт гарсан сурлага, хөгжил, төлөвшлийн ахиц, амжилтаар тус тус үнэлж, чанар, үр ашгийг тоон хэмжээсээр илэрхийлж дүгнэнэ.

3.2. "Сайн хичээл, хүүхэд хөгжүүлэх сайн үйл ажиллагаа"-ны чанар, хүртээмж, үр дүнг үнэлэх ажлыг 3 үе шаттайгаар зохион байгуулна.

3.2.1. Нэгдүгээр шат буюу цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн түвшинд

3.2.1.1. Багш нь жил бүрийн 9 дүгээр сард хүүхдийн хөгжлийн гарааны үнэлгээг тогтооно.

3.2.1.2. Хичээлийн жилийн 09 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл /эхний хагас жил/ сургуулийн өмнөх боловсролын багш 8-аас доошгүй хүүхэд хөгжүүлэх сайн үйл ажиллагаа, 4-өөс доошгүй эцэг эх олон нийтэд чиглэсэн ажил, ерөнхий боловсролын сургуулийн багш 10-аас доошгүй сайн хичээл, 5-аас доошгүй сургууль-эцэг эх, олон нийтийн хамтын ажиллагааг бэхжүүлэх ажлыг зохион байгуулж, тухайн хичээл, үйл ажиллагааны дундаж үнэлгээ нь 80-аас дээш хувийн биелэлттэй байна.

3.2.1.3. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь багшийн өөрийн үнэлгээг 1 дүгээр сард баталгаажуулж, хүүхэд нэг бүрийн ахиц амжилтыг үнэлнэ.

3.2.1.4. 3.2.1.2 дахь заалтыг хангасан багш нар өөрийн цэцэрлэг, сургуулийнхаа түвшний үнэлгээнд орох эрхтэй бөгөөд хүүхэд нэг бүрийн ахиц, амжилтын үнэлгээг цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирлын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг үнэлж тогтооно.

3.2.1.5. 1 дүгээр шатанд нийт суралцагчдын 80-аас дээш хувь нь ахиц, амжилттай үнэлэгдсэн багш дараагийн шатны үнэлгээнд оролцоно.

3.2.2. Хоёрдугаар шат буюу бүсийн түвшинд

3.2.2.1. Бүсүүд нь 3 дугаар сард хамтарсан ажлын хэсгээр тухайн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиас шалгарсан багш нарын түвшинд хүүхэд нэг бүрийн ахиц амжилтыг үнэлнэ.

3.2.2.2. Бүсийн үнэлгээнд орох багш нь 1-ээс 3 сар хүртэлх 2 сарын хугацаанд 1-ээс доошгүй сайн хичээл, үйл ажиллагааг мэргэжлийн багшийн, 1-ээс доошгүй сайн хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааг эцэг эхийн, 1-ээс доошгүй сайн хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааг цэцэрлэг, сургуулийн удирдлагын, 1-ээс доошгүй сайн хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн байгууллага, хүмүүсийн оролцоотойгоор зохион байгуулж, 90-ээс дээш хувьтай үнэлэгдсэн байна.

3.2.2.3. Бүсийн үнэлгээ хийх хамтарсан ажлын хэсгийг дүүргийн Боловсролын хэлтсийн даргын тушаалаар байгуулна.

3.2.2.4. Бүсийн түвшний үнэлгээ нь сургуулийн түвшний үнэлгээний баталгаажуулалт болно.

3.2.2.5.2 дугаар шатанд нийт суралцагчдын 85-аас дээш хувь нь ахиц, амжилттай үнэлэгдсэн багш дараагийн шатны үнэлгээнд оролцоно.

3.2.3. Гуравдугаар шат буюу дүүргийн түвшинд

3.2.3.1. Дүүргийн түвшинд цэцэрлэг, сургууль, бүсийн түвшинд шалгарсан, эрх авсан багш нарын хүүхэд нэг бүрийн ахиц амжилтыг 5 дугаар сард баталгаажуулж, үнэлнэ.

3.2.3.2. Дүүргийн ажлын хэсэг нь Засаг даргын захирамжаар байгуулагдах бөгөөд эцэг эх, багш, олон нийтийн оролцоотой байна.

3.2.3.3. Дүүргийн үнэлгээнд орох багш нь 1-ээс 3 сар хүртэлх 2 сарын хугацаанд 1-ээс доошгүй сайн хичээл, үйл ажиллагааг мэргэжлийн багшийн, 1-ээс доошгүй сайн хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааг эцэг эхийн, 1-ээс доошгүй сайн хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааг цэцэрлэг, сургуулийн удирдлагын, 1-ээс доошгүй сайн хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн байгууллага, хүмүүсийн оролцоотойгоор зохион байгуулж, 95-аас хувьтай үнэлэгдсэн байна.

3.2.3.4. Бүсээс шалгарч, дүүргийн үнэлгээнд орох багш нь өөрийн цэцэрлэг, сургуулийн заах аргын нэгдэл, удирдлагын зөвлөлийн хурлаар орсон хурлын тэмдэглэлийг дүүргийн Боловсролын хэлтэст ирүүлэх ба дүүргийн шалгаруулалтанд орох багш ёс зүйн зөрчил, захиргааны хариуцлага хүлээгээгүй байна.

3.2.3.5.3 дугаар шатанд нийт суралцагчдын 90-ээс дээш хувь нь ахиц, амжилттай үнэлэгдсэн багш нарт урамшуулал олгох саналыг дүүргийн Засаг даргын зөвлөлд өргөн мэдүүлнэ.

3.2.3.6. Дүүргийн түвшний үнэлгээ нь бүсийн түвшний үнэлгээний баталгаажуулалт болно.

Дөрөв. Шалгуур үзүүлэлт

4.1. Сургуулийн өмнөх, бага боловсролын багш нарыг үнэлэх шалгуур үзүүлэлт

4.1.1. Хүүхдийн хөгжлийн ахицыг бүлгийн хүүхэд нэг бүрийн ахисан түвшний судалгаанд үндэслэн үнэлнэ. /Хөгжим, биеийн тамирын багш нарын үнэлгээг нэг бүлгийн хүүхдийн чадамжийн судалгаанд үндэслэн авч болно/.

4.1.2. Сургалтын хөтөлбөрөө байгууллагынхаа үзэл баримтлалыг үндэслэн чанартай боловсруулж, хэрэгжилтийн явцад засан сайжруулсан байдлыг харгалзан үнэлнэ.

- 4.1.3. Хүүхдийн хөгжлийг дэмжсэн орчны бүрдүүлэлт нь эрх зүй, материаллаг, үйлийн, сэтгэл зүйн орчны шаардлагыг хангасан байна.
 - 4.1.4. Хүүхэд бүрийн онцлогийг илрүүлэх, ахиц амжилтыг тооцсон чөлөөт ажиглалтын болон "Хувийн хавтас"-ны мэдээлэлтэй байна.
 - 4.1.5. Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, сайжруулах, эрүүл харилцааг бүрдүүлэх чиглэлээр хийсэн нийт ажлуудыг тодорхой үр дүнд хүрсэн ажлын харьцаагаар тодорхойлно.
 - 4.1.6. Эцэг эх, олон нийтийн дунд зохион байгуулсан ажлуудын чанар, гүйцэтгэл, оролцоо, үр дүнг санал асуулгын дүнгээр үнэлнэ.
- 4.2. Суурь боловсролын багш нарыг үнэлэх шалгуур үзүүлэлт
- 4.2.1. Хүүхдийн сурлага, хөгжил, төлөвшлийн ахицыг тухайн багшийн хичээл ордог анги бүлгийн хүүхэд нэг бүрийн ахисан түвшний судалгаанд үндэслэн үнэлнэ.
 - 4.2.2. Сургалтын хөтөлбөрөө байгууллагынхаа үзэл баримтлалыг үндэслэн чанартай боловсруулж, хэрэгжилтийн явцад засан сайжруулсан байдлыг харгалзан үнэлнэ.
 - 4.2.3. Мэргэжлийн хичээлийн кабинетад хүүхдийн хөгжлийг дэмжсэн орчны бүрдүүлэлт нь эрх зүй, материаллаг, үйлийн, сэтгэл зүйн орчны шаардлагыг хангасан байна. Кабинетгүй мэргэжлийн багш нарын хувьд хэрэглэгдэхүүн, гарын авлагыг тооцно.
 - 4.2.4. Хүүхэд бүрийн онцлогийг илрүүлэх, тэдгээртэй ажиллах арга зүй, аргачлалаа тодорхойлсон, ахиц амжилтыг тооцсон судалгаа, тэмдэглэл, мэдээлэлтэй байна.
 - 4.2.5. Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, сайжруулах, эрүүл харилцааг бүрдүүлэх чиглэлээр хийсэн нийт ажлуудыг тодорхой үр дүнд хүрсэн ажлын харьцаагаар тодорхойлно.
 - 4.2.6. Эцэг эх, олон нийт, сургууль хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажлуудын чанар, гүйцэтгэл, оролцоо, үр дүнг санал асуулгын дүнгээр үнэлнэ.

Тав. Дүгнэх аргачлал

- 5.1. Дүгнэх аргачлалын дагуу зөвлөмж боловсруулан мөрдөнө.
 - 5.1.1. Шалгуур үзүүлэлтүүд (4.1.1-4.1.6, 4.2.1-4.2.6)-ийг хэрхэн тооцож, дүгнэх аргачлалын талаарх зөвлөмжийг сургуулийн өмнөх, бага, суурь боловсрол тус бүрээр боловсруулан, дүүргийн Боловсролын хэлтсийн даргын тушаалаар баталгаажуулж, дагаж мөрдөнө.
 - 5.1.2. Цэцэрлэг, сургуулийн эрхлэгч, захирал, арга зүйч, сургалтын менежерүүдийг журмыг хэрхэн дагаж мөрдөх арга зүйн удирдлагаар ханган, хэрхэн дагаж мөрдөх сургалт, семинарыг Боловсролын хэлтэс хариуцан зохион байгуулна.

5.2. Шалгуур үзүүлэлтийг дараах аргачлалын дагуу дүгнэнэ.

№	Шалгуур үзүүлэлт	Дүгнэх аргачлал		Авах оноо
1	Хүүхдийн хөгжлийн ахиц	$A = \frac{A_1}{A_2}$	A ₁ -Хөгжлийн түвшин нь ахисан хүүхдийн тоо	
			A ₂ -Тухайн бүлгийн хүүхдийн тоо	
			Суурь боловсролын түвшинд A ₂ нь хичээл ордог нийт хүүхдийн тоо байна.	
2	Хөтөлбөрийн индекс	$B = \frac{B_1 + B_2}{2}$	B ₁ -Сургалтын хөтөлбөр боловсруулсан байдал	B ₁ , B ₂ - үзүүлэлтүүд эд тус бүр 1 хүртэл оноо өгнө
			B ₂ -Сургалтын хөтөлбөр хэрэгжүүлсэн байдал	
3	Орчны бүрдүүлэлт, хэрэглэгдэхүүн гарын авлага	$C = \frac{C_1 + C_2}{2}$	C ₁ -Хүүхдийн хөгжлийг дэмжсэн орчны бүрдүүлэлт	C ₁ , C ₂ - үзүүлэлтүүд эд тус бүр 1 хүртэл оноо өгнө
			C ₂ -Хэрэглэгдэхүүн, гарын авлага материалын бүрдэлт	
			Суурь боловсролын түвшинд C ₂ нь гарын авлага, хэрэглэгдэхүүнийг тооцож болно	
4	Хүүхэд бүрийг хөгжүүлсэн ажлын индекс	$D = \frac{D_1 + D_2}{2}$	D ₁ -Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжсэн ажлын үзүүлэлт	D ₁ , D ₂ - үзүүлэлтүүд эд тус бүр 1 хүртэл оноо өгнө
			D ₂ -Хүүхдийн хөгжлийн онцлогийг илрүүлэн, арга аргачлал боловсруулан баримтжуулсан байдал	
5	Хүүхдийг эрүүл мэндийн чиглэлээр хийсэн үр дүнтэй ажлын индекс	$F = \frac{F_1}{F_2}$	F ₁ -Үр дүнд хүрсэн ажлууд	
			F ₂ -Хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах чиглэлээр хийсэн нийт ажлууд	
6	Эцэг эхийн дунд зохион байгуулсан ажлын индекс	$H = \frac{H_1}{H_2}$	H ₁ -Хангалттай үнэлгээ өгсөн эцэг эхийн тоо	/Санал асуулгаар/
			H ₂ -Санал асуулгад оролцсон нийт эцэг эхийн тоо	
Нийт оноо-7		$S = 10 * A + 8 * B + 6 * C + 4 * D + 2 * F + H$		

5.3. Үнэлгээ

- 5.3.1. Дүгнэх аргачлалын дагуу нийт суралцагчид нь 90-100 хувийн ахиц, амжилттай үнэлэгдсэн багш нарыг дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, урамшуулал олгох эсэхийг шийдвэрлэнэ. Засаг даргын зөвлөлийн хурлаар ижил түвшний оноотой багш нарыг онцгойлсон, гоц амжилтуудыг чухалчилж үзнэ.
- 5.3.2. Дүгнэх аргачлалын дагуу нийт суралцагчдын 80-89 хувь нь ахиц, амжилттай үнэлэгдсэн багш нарт 2 дугаар шат буюу бүсийн ажлын хэсэг зөвлөн тусалж, цэцэрлэг, сургуулийн түвшинд урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэнэ.
- 5.3.3. Дүгнэх аргачлалын дагуу нийт суралцагчдын 60-79 хувь нь ахиц, амжилттай үнэлэгдсэн багш нарт цэцэрлэг, сургуулийн түвшинд зөвлөн тусалж, ажил сайжруулна.
- 5.3.4. Дүгнэх аргачлалын дагуу нийт суралцагчдын 60-аас доош хувь нь ахиц, амжилттай үнэлэгдсэн багш нарыг мэргэжил дээшлүүлэх сургалт семинарт хамруулах, цэцэрлэг, сургуулийн удирдлагуудын баг бие даан хариуцах, ажил сайжруулах арга хэмжээ авна.

Зургаа. Урамшуулал олгох

- 6.1. Урамшууллыг жил бүрийн 10 дугаар сарын 05 буюу Монгол багш нарын өдрөөр олгоно.
- 6.2. Урамшууллын хэмжээ 500,000-1,000,000 төгрөг хүртэл байна.
- 6.3. Урамшуулал олгох багшийн тоо, нэрсийг тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ.
- 6.4. Урамшууллыг дүүргийн удирдах ажилтнуудын түвшинд ёслол хүндэтгэлтэй гардуулж, багш нарыг алдаршуулж, олон нийтэд сурталчилна.

Долоо. Санхүүжилт, хяналт

- 7.1. Урамшууллын хэмжээг жил бүр дүүргийн төсөвт суулган санхүүжүүлнэ.
- 7.2. Урамшууллыг багш бүрийн дансанд бэлэн бусаар шилжүүлнэ.
- 7.3. Журмын хэрэгжилт, үр дүнг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнана.



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2016 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Төсөвт зохицуулалт хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалт, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 3.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс баталсан “Амар тайван Чингэлтэй” хөтөлбөрийг хэрэгжүүлэх, гэмт хэрэг зөрчлөөс урдчилан сэргийлэх, иргэдийн амгалан орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллах шаардлагаар Хурлын төсвийн Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд батлагдсан 770.0 сая төгрөгийн 516.235 мянган төгрөгийг Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглээр хавсралтад заагдсан ажилд, 20.0 сая төгрөгийг Багаж техник хэрэгсэл зардалд, 100.0 сая төгрөгийг Бараа үйлчилгээний зардалд, 133.8 сая төгрөгийг Нэг удаагийн тэтгэмж урамшуулал зардалд тус тус шилжүүлэн төсөвт зохицуулалт хийхээр шийдвэрлэсүгэй.

2. Төсөвт хийсэн зохицуулалтын гүйцэтгэлийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит хуралдаанд тайлагнахыг Төсвийн захирагчид үүрэг болгосугай.

ДАРГА



Д. БАТ-ЭРДЭНЭ

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 03 дугаар сарын
23-ны өдрийн 24 дүгээр тогтоолын хавсралт



ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ЖАГСААЛТ

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд	516.235 мянган
• Гудамж байрны нийтийн эргүүл нарын шагнал	150.0 сая
• Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 3 сарын аян	14.1 сая
• Тайван хороо-Таны оролцоо аяны зардал /10 хороо/	20.0 сая
• Гудамж байрны нийтийн эргүүл нарын нэгдсэн сургалт	22.135 сая
• Цагдаагийн 2 дугаар хэлтсийн тавилга, тоног төхөөрөмж	25.0 сая
• 19 хорооны гудамж талбайн камержуулалт	285.0 сая

“ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОН”-ООР:

- | | |
|----------------------------|---|
| 1. Дагвадоржийн Ганбаатар | Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны ахмад настан |
| 2. Шаравдоржийн Намшир | Чингэлтэй дүүргийн Цагдаагийн 2 дугаар хэлтэст зөвлөх |
| 3. Рэгзэнгийн Эрдэнэчулуун | Чингэлтэй дүүргийн 15 дугаар хорооны ахмад настан |

“АЛТАН ГАДАС ОДОН”-ООР:

- | | |
|----------------------------|---|
| 1. Пүүжиндоржийн Бямбахүү | Малчин телевизийн сэтгүүлч |
| 2. Ванчингийн Мижиддорж | Чингэлтэй дүүргийн 6 дугаар хорооны ахмад настан |
| 3. Доржийн Алимаа | Улаанбаатар-Эрдэм Их сургуулийн захирал |
| 4. Гэндэнсүрэнгийн Гүнсмаа | Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооны “Чин хүслэн” өрхийн эрүүл мэндийн төвийн дарга |
| 5. Осоржамаагийн Баасан | Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны ахмад настан |
| 6. Ваанчигийн Энхтунгалаг | Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны ахмад настан |

“ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛЬ”-ИАР:

- | | |
|-------------------------|--|
| 1. Ядамдоржийн Рина | Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооны ахмад настан |
| 2. Тамжидын Ойхүү | Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооны “Чин хүслэн” өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагч |
| 3. Гүнжээгийн Сүглэгмаа | Улаанбаатар-Эрдэм Их сургуулийн Сургалтын албаны дарга |
| 4. Сэнгэдоржийн Энхбаяр | “Сонгино” амралтын сувилагч |

ДАРГА

Д.БАТ-ЭРДЭНЭ





**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2016 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

Шагналд уламжлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.8 дахь заалтыг үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улсад олон жил үр бүтээлтэй ажиллаж байгаа зарим хүмүүсийн хөдөлмөр бүтээлийг үнэлж, Төрийн дээд шагнал, цол, одон медалиар шагнуулахаар тодорхойлсон байгууллага, хамт олны саналыг дэмжиж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд уламжилсугай. Үүнд:

МОНГОЛ УЛСЫН “ГАВЬЯАТ ЖҮЖИГЧИН ЦОЛ”-ООР:

- | | |
|-----------------------|--|
| 1. Жаргалын Баасанхүү | Чингэлтэй дүүргийн 15 дугаар хорооны иргэн |
|-----------------------|--|

МОНГОЛ УЛСЫН “ГАВЬЯАТ БАГШ ЦОЛ”-ООР:

- | | |
|----------------------|--|
| 1. Сэнгээгийн Цээпэл | Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны ахмад настан |
|----------------------|--|

МОНГОЛ УЛСЫН “СОЁЛЫН ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН ЦОЛ”-ООР:

- | | |
|---------------------|-----------------------------------|
| 1. Татегийн Етекбай | Хэвлэлийн “Дастан” ХХК-ний зөвлөх |
|---------------------|-----------------------------------|

“ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОН”-ООР:

- | | |
|------------------------|--|
| 1. Туулайн Нагваанжамц | Улаанбаатар-Эрдэм Их сургуулийн Сургалт эрхэлсэн дэд захирал, зөвлөх |
|------------------------|--|

“Д.СҮХБААТАРЫН ОДОН”-ООР:

- | | |
|-----------------------|--|
| 1. Доржийн Цэрэндулам | Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны ахмад настан |
|-----------------------|--|



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2016 оны 03 сарын 23 өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

Шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 165 дугаар тогтоолыг тус тус үндэслэн дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дүүргийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж, эрхэлсэн ажилдаа амжилт гарган ажиллаж байгаа хавсралтад нэр дурьдсан иргэдийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналаар шагнасугай.

2. Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Чандмань одонгоор шагнагдах иргэдийн нэрсийг нэгдүгээр, Хурлын Хүндэт өргөмжлөлөөр шагнагдах иргэдийн нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Шагналд шаардагдах зардлыг Хурлын төсвийн зардлаас гаргахыг Хурлын Ажлын алба /Ц.Алтанцацрал/-нд зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.БАТ-ЭРДЭНЭ

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 03 дугаар сарын 23-ны
өдрийн 26 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

“Чандмань одон”-гоор шагнагдах хүмүүсийн нэрс

д/д	Овог нэрс	Эрхэлсэн ажил, мэргэжил	Регистрийн дугаар
1	Д.Оюунгэрэл	Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хорооны “Нандин хүсэл” өрхийн эрүүл мэндийн төвийн их эмч	УД60112601
2	Ш.Сэлэнгэ	Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хорооны “Нандин хүсэл” өрхийн эрүүл мэндийн төвийн их эмч	ЕП60081603
3	Ё.Жигмэд	Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооны ахмад настан	ЗН60032219
4	Ц.Ганболд	Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн 2 дугаар хэлтсийн Мөрдөн байцаах тасгийн дарга	ОЮ75062893
5	Д.Нямлхагва	Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн 2 дугаар хэлтсийн Нийтийн хэв журам хамгаалах тасгийн эргүүлийн офицер	ХЕ74031719
6	Д.Пүрэвдулам	Чингэлтэй дүүргийн 103 дугаар цэцэрлэгийн арга зүйч	ИЦ73052403
7	Ж.Оюунцэцэг	Чингэлтэй дүүргийн 174 дүгээр цэцэрлэгийн ахлах тогооч	ЧТ63062505
8	Б.Өлзийбаяр	Чингэлтэй дүүргийн 13 дугаар хорооны ахмад настан	ЕП56010106
9	Э.Мягмарсүрэн	Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны “Таны итгэл” өрхийн эрүүл мэндийн төвийн дарга	РЭ87010608
10	П.Ганбаатар	Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны иргэн	ХН60102011
11	Ш.Хашбаатар	Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны иргэн	ГЮ65050271
12	Ц.Цэндсүрэн	Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны иргэн	ЖВ61102001
13	Н.Лхагва	Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны иргэн	Х356101706
14	Х.Отгонбаяр	Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны ахмад настан	ХН58061109
15	Ж.Бадамцэцэг	Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны хэсгийн ахлагч	ИЭ66050868
16	Ч.Нансалмаа	Чингэлтэй дүүргийн 17 дугаар хорооны хэсгийн ахлагч	ХН48112005
17	Д.Эрдэнэбаяр	Чингэлтэй дүүргийн 11 дүгээр хорооны	УП89072415

		хэсгийн байцаагч	
18	Б.Гантунгалаг	Чингэлтэй дүүргийн 11 дүгээр хорооны олон нийтийн цагдаа	АЮ70082065
19	Б.Сайзмаа	Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн Мэдрэлийн тасгийн их эмч	ХЖ71110908
20	Ч.Мягмарсүрэн	Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн Цахилгаан эмчилгээний сувилагч	ЙЖ80121606
21	Б.Оюумаа	Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн Мэдрэлийн их эмч	ЦГ66061728
22	Т.Нямжав	Өрхийн эрүүл мэндийн төв хариуцсан чанарын менежер	ПЮ71050267
23	Д.Батбилэг	Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн Эмэгтэйчүүдийн их эмч	ЦГ68042211
24	Б.Цэцэгмаа	Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны ахмад настан	НК51042701
25	Ц.Энхцэцэг	Чингэлтэй дүүргийн эмэгтэйчүүдийн зөвлөлийн Нарийн бичгийн дарга	ЖБ63072660
26	Г.Нарантуяа	Чингэлтэй дүүргийн 11 дүгээр хорооны хэсгийн ахлагч	ХЙ66041308
27	Б.Алтансолонго	Чингэлтэй дүүргийн 11 дүгээр хорооны хэсгийн ахлагч	НА75121571
28	Д.Бат-Орших	Чингэлтэй дүүргийн 11 дүгээр хорооны хэсгийн ахлагч	ХД57091203
29	Б.Цогтбаатар	Чингэлтэй дүүргийн 11 дүгээр хорооны хэсгийн ахлагч	ИЭ68031810
30	В.Жаргал	Чингэлтэй дүүргийн 11 дүгээр хорооны иргэн	ХН75060405
31	К.Жанылган	Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч	БЮ65031021
32	Г.Сосорбарам	Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны ахмад настан	ЖБ48021664
33	А.Намхай	Чингэлтэй дүүргийн 16 дугаар хорооны иргэн	ЧО64040701
34	Ц.Даш	Чингэлтэй дүүргийн 39 дүгээр сургуулийн газарзүйн багш	ДБ93051015
35	Ц.Алтанцэцэг	Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны иргэн	ЖЯ70051965
36	С.Цэвэгжав	Чингэлтэй дүүргийн 5 дугаар хорооны ахмад настан	ХИ37061500
37	Д.Уранчимэг	Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн дүн бүртгэгч	ХЕ62042907
38	Ж.Пүрэв	Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооны ахмад настан	ЙД52050210
39	Я.Нарангэрэл	Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооны ахмад настан	УХ43070189
40	Р.Сумъяа	Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооны ахмад настан	ХЙ60121274
41	А.Болд	Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооны иргэн	ШЕ62071838
42	Д.Отгонбаяр	Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооны иргэн	ХД62091217

43	П.Энхцэцэг	Чингэлтэй дүүргийн 15 дугаар хорооны иргэн	УС79081206
44	Х.Энхтуяа	Чингэлтэй дүүргийн 15 дугаар хорооны иргэн	ЖЮ65042722
45	Х.Жаргал-Өлзий	Чингэлтэй дүүргийн 15 дугаар хорооны иргэн	АЮ83031003
46	Ц.Наянтай	Чингэлтэй дүүргийн 15 дугаар хорооны иргэн	АЖ81011910
47	Д.Баттулга	Чингэлтэй дүүргийн 15 дугаар хорооны иргэн	УС85040617
48	Б.Пүрэв-Эрдэнэ	Чингэлтэй дүүргийн Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн техник үйлчилгээний хэсгийн ахлагч	ЧТ83112471
49	Б.Болормаа	Чингэлтэй дүүргийн Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн борлуулалтын хэсгийн ахлагч	ЦД73012961
50	Б.Роза	Чингэлтэй дүүргийн 16 дугаар хорооны ахмад настан	ХМ42011215
51	Н.Цэрэнчимэд	Чингэлтэй дүүргийн 16 дугаар хорооны ахмад настан	ХМ43070102
52	Г.Цэрэнхүү	Чингэлтэй дүүргийн 16 дугаар хорооны ахмад настан	УХ33061503
53	Б.Тунгалаг	Чингэлтэй дүүргийн 16 дугаар хорооны хэсгийн ахлагч	ДИ71042102
54	М.Пүрэвдорж	Чингэлтэй дүүргийн 16 дугаар хорооны "Тэгш-Өлзий" өрхийн эрүүл мэндийн төвийн дарга	ХМ49250214
55	Г.Гүнсмаа	Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооны "Чин хүслэн" өрхийн эрүүл мэндийн төвийн дарга	ВЕ63090805
56	Д.Бурмаа	Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооны "Чин хүслэн" өрхийн эрүүл мэндийн төвийн эмч	ДИ62112906
57	Г.Энхжаргал	Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооны "Чин хүслэн" өрхийн эрүүл мэндийн төвийн эмч	НЧ85073105

Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 03 дугаар сарын 23-ны
өдрийн 26 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



“Хүндэт өргөмжлөл”-өөр шагнагдах хүмүүсийн нэрс

д/д	Овог нэрс	Эрхэлсэн ажил, мэргэжил	Регистрийн дугаар
1	Б.Мөнхбаяр	Чингэлтэй дүүргийн 9 дүгээр хорооны “Нандин хүсэл” өрхийн эрүүл мэндийн төвийн нийгмийн ажилтан	УЗ97051518
2	Б.Зоригтсайхан	Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн 2 дугаар хэлтсийн Нийтийн хэв журам хамгаалах тасгийн цагдаа жолооч	ЗЖ76071118
3	П.Оюунжаргал	Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны “Таны итгэл” өрхийн эрүүл мэндийн төвийн Нийгмийн ажилтан	ПЮ88071541
4	Э.Нарантуяа	Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны “Таны итгэл” өрхийн эрүүл мэндийн төвийн их эмч	МЮ87030801
5	Б.Цэндмаа	Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны “Таны итгэл” өрхийн эрүүл мэндийн төвийн сувилагч	Й388100600
6	П.Тогоохүү	Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны “Таны итгэл” өрхийн эрүүл мэндийн төвийн Сайн санааны туслагч	ЗН57042701
7	Б.Болормаа	Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн Рентген техникч	ХО70011860
8	П.Мандахтуяа	Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн Шүдний кабинетын сувилагч	НЮ81112505
9	Т.Эрдэнэбаяр	Чингэлтэй дүүргийн Эрүүл мэндийн төвийн Мэдрэлийн тасгийн сувилагч	МФ84050604
10	А.Алтансүх	Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны хэсгийн байцаагч	УЖ82121215
11	Л.Ганзориг	Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны иргэн	МБ81091016
12	Г.Урангуа	Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны иргэн	ЖЮ85012701
13	Д.Амгаланбаяр	Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны иргэн	ВА80073115
14	“Есүсийг дагалдагч” цуглааны хамт олонд	Чингэлтэй дүүргийн 18 дугаар хороо	1044672
15	Б.Эрдэнэсүвд	Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооны “Чин хүслэн” өрхийн эрүүл мэндийн төвийн эмч	СЭ89101364